



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2022/06



sukhbaatar.nso.mn

www.nso.mn

www.1212.mn



Хэрэглэгч та Статистикийн
тоон мэдээллийн 1212.mn
аппликейшнаар авна уу.



Хэрэглэгч та өөрийн гар
утаснаас QR code уншуулагч
аппликейшни ашиглан тухай
сарын мэдээллийг авч үзэх.
/интернетэд холбогдсон байх/



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

6 сар
2022

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-15
Үндсэн үзүүлэлтүүд	16

I. Нийгмийн үзүүлэлт

I.1 Хөдөлмөр	17-19
I.2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж	20-21
I.3 Боловсрол	22-23
I.4 Эрүүл мэнд	23-25
I.5 Соёл, урлаг	25-26
I.6 Газар өмчлөл	26-27
I.7 Гэмт хэрэг	27-29

II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Мөнгө, банк, даатгал	29-30
II.2 Төрийн санхүү	30-33
II.3 Төсөл хөтөлбөр	33
II.4 Үнэ	34-35
II.5 Хөдөө аж ахуй	36-40
II.6 Аж үйлдвэр	41-43
II.7 Тээвэр	44



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал:

Сумдын нэр:

АС Асгат

ТШ Түвшинширээ

БД Баяндэлгэр

ТЦ Түмэнцогт

ДА Дарьганга

УБ Уулбаян

МХ Мөнххаан

ХА Халзан

НА Наран

ЭЦ Эрдэнэцагаан

ОН Онгон

БУ Баруун-Урт

СҮ Сүхбаатар

Төл гэсэн нь төлөвлөгөө, Гүйц гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI, VII ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

х Бүтцийн өөрчлөлт

0.0 Маш бага тоо

+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй

* Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 22-21 нь 2021 оны үзүүлэлт тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.



- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкнуудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ. Төсвийн мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Газар тариалангийн эцсийн мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулах ба аж ахуй нэгж байгууллагууд сумын тамгын газарт салбар хариуцсан ажилтанд өгч нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа Нэгдсэн үндэсний байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Хүн ам

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээгээр 2022 оны эхний 6 сард 505 хүүхэд шинээр мэндэлж, 152 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 353 болж урьд оны мөн үеэс 189 (34.8%) хүнээр буурсан. 1000 хүнд ногдох төрөлт 7.9 нас баралт 2.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 3.3 пунктээр, нас баралт 0.3 пунктээр буурсан байна.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо




I.2 Хөдөлмөр

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2022 оны 6 дугаар сарын эцэст 662 болсны 256 (36.7%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 519 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 96 (22.7%) хүнээр өссөн байна.

Эхний 6 дугаар сарын байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1170 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 258 (22.1%) иргэн ажилд зуучлагдан оржээ.

Зураг.I.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд






Ажилгүй иргэдийн 408 (78.6%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2 (0.3%) нь магистр, доктор, 90 (17.3%) нь бакалавр, 15 (2.9%) нь тусгай дунд, 34 (6.6%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 287 (55.3%) нь бүрэн дунд, 64 (12.3%) нь суурь, 21 (4.0%) нь бага боловсролтой, 6 (1.2%) боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр



1.3 Нийгмийн даатгал, халамж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 9.0 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 0.8 (10.2%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 0.9 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх онтой харьцуулахад 0.3 (55.6%) тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт 9.3 мянган иргэнд 27.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 7.1 мянган өндөр настанд 21.5 тэрбум төгрөг, 1.4 мянган тахир дутуу иргэнд 3.1 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 0.9 тэрбум төгрөг, 0.3 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 1.7 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 0.03 мянган иргэнд 0.7 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна.

Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84 (0.9%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 6.8 (33.6%) тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр 6 сард 24.6 мянган иргэнд 5.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнийг төрлөөр нь авч үзвэл: Улсын төсвөөс нийгмийн халамжийн тэтгэвэрийг 1.3 мянган иргэнд 2.2 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 2.1 мянган иргэнд 565.1 сая төгрөг, алдарт эхийн одонтой 5.3 мянган эхчүүдэд 704.5 сая төгрөгийг, насны хишиг 2.8 мян иргэнд 223.8 сая төгрөгийг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 3.1 иргэнд 165.9 сая төгрөгийг, бусад хөнгөлөлт, тусламж, дэмжлэгт 10.0 мянган иргэнд 1717.6 сая төгрөгийг тус тус олгожээ.




I.4 Боловсрол

Ерөнхий боловсролын сургуулийг 2021-2022 оны хичээлийн жилд 2972 сурагчид өдрөөр төгсжээ. Үүнээс: бага боловсролыг 1439 (48.4%), суурь боловсролыг 943 (31.7%), бүрэн дунд боловсролыг 590 (19.9%) сурагчид тус тус эзэмшжээ. Өнгөрсөн оны мөн үеэс нийт төгсөгчдийн тоо 187 (6.7%) суралцагчдаар өссөн байна.

Нийт төгсөгчдийн 1528 (50.4%) эмэгтэй сурагчид байна.


Зураг I.4.2 Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоо



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв:

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2021-2022 оны хичээлийн жилд 9 мэргэжлээр 272 хүүхэд төгссөний 95 (35.0%) эмэгтэй хүүхэд байна. Нийт төгсөгчдийн 151 (55.5%) мэргэжлийн боловсролыг 1 жилийн хугацаатай, 121 (44.5%) 2.5 жилийн хугацаатай мэргэжлийн боловсролыг эзэмшжээ. Өмнөх оны мөн үеэс төгсөгчдийн тоо 86 (46.2%) суралцагчдаар өсчээ. Нийт төгсөгчдийн 134 (49.3%) суралцагчид ажлын байртай болсон байна.

Зураг I.4.5 Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо






I.5 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд эхний 6 сарын байдлаар 126.3 мянган хүнд үзлэг хийсэн ба урьдчилан сэргийлэх үзлэгт 26.7 мянган хүн хамрагдаж, 7.9 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 18.3 (17.1%) хүнээр өсч, урьдчилан сэргийлэх үзлэг 10.6 (28.3%) мянган хүнээр буурчээ.

Түргэн тусламжийн дуудлага 8.7 мянган удаа гарсны 1.6 (19.0%) мянга нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага 0.2 (11.8%) мянган хүнээр буурсан байна

Зураг.I.5.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо




Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 6 сард 3551 болж, өмнөх оны мөн үеэс 2281 (2.7 дахин) тохиолдлоор өсөхөд салхинцэцэг 3 (50%), 2327 (3.1 дахин), короновируст /ковид-19/ халдвар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.




I.6 Соёл, урлаг:

Хөгжимд жүжгийн театр: 3.0 мянган үзэгчдэд 13 тоглолтоор үйлчилж 6.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс үзэгчдийн тоо 5 дахин, тоглолтын тоо 3 дахин, орлогын хэмжээ 6.4 дахин тус тус өсчээ.

Зураг I.6.1 Нийт тоглолтын тоо




Зураг I.6.2 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Музей: 2.3 мянган үзмэрээр 6.4 мянган хүнд үйлчилж 350.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзэгчдийн тоо 160 дахин үзмэрийн тоо 1.5 хувиар өссөн байна.



Зураг I.6.3 Нийт үзмэрийн тоо




Зураг I.6.4 Нийт үзэгчдийн тоо, мян.хүн




Номын сан: Нийт 49.2 мянган номоор 5.1 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.3 (0.7%) мянгаар өсч, уншигчдын тоо 4.6 мянган (47.4%) хүнээр буурчээ.

Зураг I.6.5 Нийт номын тоо




Зураг I.6.6 Нийт уншигчдын тоо, мян.хүн




I.6 Газар өмчлөл:

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 11.3 мянган иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 10.4 мянган иргэнд 990.4 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байна.

Зураг I.6.1 Газар өмчлөх өргөдөл гаргасан иргэдийн тоо



Зураг I.6.2 Засаг даргын шийдвэр гарсан иргэдийн тоо






I.7 Гэмт хэрэг

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны 6 дугаар сард 313 болж, өмнөх оноос 134 (74.9%)-өөр өсчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 81 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 1.2 тэрбум төгрөгийн хохирол учирсны 48.1 хувийг нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэрэгт 252 хүн холбогдон сэжиглэгдсэний 75 (29.8%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.

Нийт 224 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 35 (18.5%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 109 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 45.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.8 пунктээр өссөн байна.

Зураг.I.7.1 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 199.2 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 11.5 (5.8%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 56.8 (39.9%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 142.2 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 8.1 (5.7%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 48.3 (5.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 6 дугаар сарын эцэст 1.3 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.6 хувийг эзэлж байна.

Зураг.II.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, тэрбум.төг






Даатгал: Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 579.82 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 363.78 (2 дахин) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нөхөн төлбөр 1004 хүнд 125.23 сая төгрөг олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 22.7 сая, жолоочийн хариуцлагад 53.2 сая, иргэдийн эд хөрөнгөнд 1.6 сая, гэнэтийн осолд 8.4 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 38.9 сая, хурдан морь унаач хүүхдийн даатгалд 0.3 сая төгрөгийг тус тус олгожээ.

Зураг. II.1.2 Даатгалын төрлөөр




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого 2022 оны эхний 6 сард 32.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.5 (17.2%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 29.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.2 (21.1%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Орон нутгийн төсөвт 7.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 (17.7%) тэрбум төгрөгөөр өссөн гүйцэтгэлтэй гарчээ.

Эхний хагас жилд Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 3.9 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 0.6 (13.3%) тэрбум төгрөгөөр буурч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 5.7 тэрбум төгрөг авсан нь өмнөх оны мөн үеэс 2.0 (36.1%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг. II.2. Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг





II.3 Төсөл хөтөлбөр: Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэмжээнд 19 иргэнд 64.0 сая, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хэмжээнд иргэнд 48.7 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 12 иргэнд 27.0 сая, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 25 иргэнд 115.0 сая, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 15 өрхөд 65.0 сая төгрөгийн төсөл санхүүжилтийг тус тус олгоод байна.




II.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2026 оны 6 дугаар сард өмнөх сараас 1.9 хувь, өмнөх оны мөн үеэс 17.6 хувь, жилийн эцсээс 9.6 хувиар тус тус өссөн.

Зураг.II.4.1 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Ерөнхий индекс жилийн эцсээс 9.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 15.6 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 1.5 хувь, хувцас бөс барааны бүлгийн үнэ 2.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 6.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 16.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 19.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 6.9 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 2.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 9.7 хувь, бусад бараа, үйлчилгээ 12.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



Хүснэгт.II.4.1 Хэрэглээний үнийн үнийн индекс, бүлгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2022.VI}{2021.VI}$	$\frac{2022.VI}{2021.XII}$	$\frac{2022.VI}{2021.V}$
Ерөнхий индекс	117.6	109.6	101.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	120.0	115.6	102.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	104.6	101.5	100.8
Хувцас, бөс бараа, гутал	112.7	102.9	100.1
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	115.3	106.0	101.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	125.8	116.2	103.6
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	128.3	119.6	107.8
Тээвэр	124.4	106.9	101.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	103.3	102.4	100.0
Боловсролын үйлчилгээ	103.5	102.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	112.3	109.7	102.5
Бусад бараа, үйлчилгээ	115.6	112.2	101.2

**II.5 Хөдөө аж ахуй**

Мал төллөлт төл бойжилт. Оны эхний төллөх насны хээлтэгч малын 1545.9 (82.6%) мянган хээлтэгч мал төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 84.8 хувь нь, эм ямаа 82.5 хувь нь, үнээ 74.7 хувь нь ингэ 41.2 хувь нь, гүү 73.9 хувь нь тус тус төллөжээ.


Гарсан төлийн 1536.4 (99.1%) мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 130.4 (9.3%) мянган толгойгоор өссөн байна.

6 дугаар сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: хурга 99.3 хувь, ишиг 98.8 хувь, унага 99.5 хувь, тугал 99.5 хувь, ботго 99.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.1-0.6 пунктээр тус тус өссөн байна.

Малын онд оролт: Том малын зүй хорогдол 2022 оны 6 дугаар сард 10.8 толгой болж өмнөх оны мөн үеэс 31.6 мянган толгой буюу 74.6 хувь буурсан байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 25 толгой, адуу 1233 толгой, үхэр 1218 толгой, хонь 3965 толгой, ямаа 4321 толгой байна. Нийт хорогдлын 36.8 хувийг хонь, 40.2 хувийг ямаа эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 6 дугаар сард 119 толгой мал өвчнөөр хорогдож нийт хорогдлын 1.2 хувийг эзэлж байна.

Зураг-II.4. Том малын зүй бус хорогдол





Газар тариалан: 2022 онд үр тариа 3.6 мянган га-д, төмс 73.5 га-д, хүнсний ногоо 45.8 га-д, тэжээлийн ургамал 0.5 мянган га-д, техникийн ургамал 2.1 мянган га-д тариалалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс төмс 11.3 (13.3%), хүнсний ногоо 5.6 (10.9%), тэжээлийн ургамал 0.5 (49.9%), техникийн ургамал 1.3 (39.5%), үр тариа 18.1 (33.5%) хувиар тус тус буурчээ.

Үр тариа 3.6 мянган га-д тариалснаас 2.9 мянган га-д улаан буудай, 0.2 мянган га-д арвай, 0.5 мянган га-д овьёос тариалсан байна.



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 23.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 4.2 (14.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 3.6 (15.1%) тэрбум төгрөг, боловсруулах аж үйлдвэрийнх 0.7 (35.1%) тэрбум төгрөг буурч, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 0.1 (4.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Оны үнээр 133.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.3 (2.6%) тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал, түгээсэн цэвэр ус, нарийн боов, хэвийн боов, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, монгол дээл, тэрлэг, гэрийн бүрээс туурга бусад хэрэгсэл, модон сандал, блок, вакуум цонх, сувагжуулалт зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс өссөн байна.



II.8 Тээвэр

Авто тээвэр бүхий байгууллагууд 2 дугаар улирлын байдлаар 73.2 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 40.1 (35.3%) мян.тн-оор буурсан байна. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: цайрын баяжмал 53.8 мян.тн болж 2.4 хувиар өсч, нүүрс 16.4 мян.тн болж 17.6 хувиар буурсан байна.

Мөн давхардсан тоогоор 11.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 1.3 (13.1%) мянган хүнээр буурчээ.

Авто тээврийн орлого 4.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.7 (58.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эцсийн байдлаар

	Хэмжих нэгж	2020	2021	2022	Зөрүү	$\frac{2022}{2021}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	656	709	505	- 204	71.2
Нялхасын эндэгдэл	хүн	7	2	6	4	300.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	434	423	519	96	122.7
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	259	1 270	3 551	2 281	279.6
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	211	179	313	134	174.9
Хэрэгт холбогсод	хүн	164	123	252	129	204.9
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар						
	хувь	101.3	104.0	109.6	5.6	-
Иргэдийн хадгаламж	сая.төг	98 677.0	154 027.2	142 149.0	-11 878.2	92.3
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	132 018.2	151 719.0	199 196.5	47 477.5	131.3
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	38 032.1	37 815.9	32 274.5	-5 541.4	85.3
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	33 425.9	35 326.9	29 178.2	-6 148.7	82.6
Төллөсөн хээлтэгч	тол	1 415 099	1 418 129	1 545 903	127 774	109.0
-Ингэ	тол	1 396	1 232	1 253	21	101.7
-Гүү	тол	75 878	81 568	86 441	4 873	106.0
-Үнээ	тол	77 019	84 137	90 475	6 338	107.5
-Эм хонь	тол	784 837	780 379	867 901	87 522	111.2
-Эм ямаа	тол	475 972	470 813	499 833	29 020	106.2
Бойжуулсан төл	тол	1 399 841	1 406 034	1 536 408	130 374	109.3
-Ботго	тол	1 364	1 217	1 241	24	102.0
-Унага	тол	75 094	80 960	85 989	5 029	106.2
-Тугал	тол	76 371	83 519	89 981	6 462	107.7
-Хурга	тол	777 506	775 875	863 774	87 899	111.3
-Ишиг	тол	469 506	464 463	495 423	30 960	106.7
Том малын зүй бусын хорогдол	тол	36 268	42 327	10 762	-31 565	25.4
- Тэмээ	тол	19	31	25	- 6	80.6
- Адуу	тол	1 320	1 922	1 233	- 689	64.2
- Үхэр	тол	2 580	4 314	1 218	-3 096	28.2
- Хонь	тол	17 694	16 736	3 965	-12 771	23.7
- Ямаа	тол	14 655	19 324	4 321	-15 003	22.4
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	136	5	119	114	2380.0
- Тэмээ	тол	-	-	-	-	-
- Адуу	тол	1	-	-	-	-
- Үхэр	тол	10	4	21	17	525.0
- Хонь	тол	60	-	45	-	-
- Ямаа	тол	65	-	53	-	-
Тариалсан талбай						
Үүнээс: Үр тариа	га	2 010.0	5 409.0	3 599.0	-1 810.0	66.5
Төмс	га	68.9	84.8	3.5	-81.3	4.1
Хүнсний ногоо	га	44.1	51.4	45.8	-5.6	89.1
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	22 432.2	28 090.3	23 913.6	-4 176.7	85.1
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	74 586.6	130 267.0	133 608.0	3 341.0	102.6

**I.2 ХӨДӨЛМӨР****I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2020		2021		2022	2022.VI 2021.VI %
	VI	XII	VI	XII	VI	
Асгат	1	10	4	8	11	2.8*
Баяндэлгэр	30	9	36	51	5	13.9
Дарьганга	42	35	24	34	34	141.7
Мөнххаан	24	7	2	38	26	13.0*
Наран	26	28	13	6	6	46.2
Онгон	28	11	20	37	4	20.0
Сүхбаатар	50	55	41	48	14	34.1
Түвшинширээ	58	57	45	83	65	144.4
Түмэнцогт	21	20	10	30	10	100.0
Уулбаян	69	32	47	10	10	21.3
Халзан	2	4	4	15	4	100.0
Эрдэнэцагаан	3	50	59	32	53	89.8
Баруун-Урт	80	144	118	171	277	234.7
Дүн	434	462	423	563	519	122.7

I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	11	2	-	1	-	3	5	2	-	-	3	4	2	2	-	-
Баяндэлгэр	5	1	-	2	-	1	2	-	-	-	2	2	1	-	-	-
Дарьганга	34	16	-	6	-	6	17	5	-	-	9	10	7	7	1	-
Мөнххаан	26	18	-	2	1	1	15	2	4	1	1	4	8	10	2	1
Наран	6	4	-	1	2	-	1	2	-	-	1	-	4	-	1	-
Онгон	4	3	-	1	-	-	3	-	-	-	1	2	1	-	-	-
Сүхбаатар	14	5	-	1	1	2	8	1	1	-	6	6	-	2	-	-
Түвшинширээ	65	32	-	11	5	5	20	20	4	-	13	19	17	14	1	1
Түмэнцогт	10	2	1	3	-	1	5	-	-	-	-	6	1	2	1	-
Уулбаян	10	5	-	4	-	2	3	-	1	-	2	6	-	1	-	1
Халзан	4	3	-	1	1	-	2	-	-	-	1	1	-	-	2	-
Эрдэнэцагаан	53	18	-	3	-	-	47	2	-	1	11	15	21	6	-	-
Баруун-Урт	277	89	1	54	5	13	159	30	11	4	38	95	88	49	7	-
Дүн	519	198	2	90	15	34	287	64	21	6	88	170	150	93	15	3



I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2020		2021		2022	$\frac{2022.VI}{2021.VI} \%$
	I-VI	I-XII	I-VI	I-XII	I-VI	
Асгат	10	30	49	95	42	85.7
Баяндэлгэр	89	156	68	193	12	17.6
Дарьганга	29	55	83	177	99	119.3
Мөнххаан	60	184	13	96	56	430.8
Наран	56	118	41	98	51	124.4
Онгон	40	122	47	141	8	17.0
Сүхбаатар	48	157	33	122	37	112.1
Түвшинширээ	109	228	93	258	162	174.2
Түмэнцогт	73	137	45	125	49	108.9
Уулбаян	102	158	50	124	16	32.0
Халзан	32	41	11	39	10	90.9
Эрдэнэцагаан	39	110	55	103	71	129.1
Баруун-Урт	255	783	501	1 018	557	111.2
Дүн	942	2 279	1 089	2 589	1170	107.4

I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2020		2021		2022	$\frac{2022.VI}{2021.VI} \%$
	I-VI	I-XII	I-VI	I-XII	I-VI	
Асгат	4	9	33	52	26	78.8
Баяндэлгэр	38	65	5	35	2	40.0
Дарьганга	16	37	14	30	27	-
Мөнххаан	13	51	3	29	19	633.3
Наран	46	79	20	52	31	155.0
Онгон	9	43	7	49	-	-
Сүхбаатар	32	110	17	21	-	-
Түвшинширээ	35	69	34	81	57	167.6
Түмэнцогт	16	33	11	43	19	172.7
Уулбаян	47	52	-	37	2	-
Халзан	17	17	3	10	4	133.3
Эрдэнэцагаан	1	9	2	7	4	200.0
Баруун-Урт	37	272	95	161	66	69.5
Дүн	311	846	244	607	258	105.7



I.2.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар										
						Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Мэргэжлийн шинжлэх ухаан	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	
	2021 I-VI	2022.I-VI														
		Бүгд	Үүнээс													
			Байнгын	Түр	Улирал											
Асгат	12	8	1	7	-	2	-	5	-	-	-	-	-	-	1	-
Баяндэлгэр	19	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	17	1	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Мөнххаан	5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	5	8	6	-	2	-	-	-	1	-	-	-	-	-	7	-
Онгон	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	8	16	2	14	-	7	-	1	-	1	1	-	5	-	-	1
Түвшинширээ	13	3	3	-	-	-	-	-	-	2	-	1	-	-	-	-
Түмэнцогт	10	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	-	7	7	-	-	1	3	-	-	-	-	-	-	-	3	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	45	102	90	-	12	-	101	1	-	-	-	-	-	-	-	-
Дүн	136	145	110	21	14	10	104	7	1	4	1	1	5	11	1	1

**I.3 НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар, сая.төг**

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого			
	2021.I-VI	2022.I-VI			2021.I-VI	2022.I-VI		
		Төл	Гүйц	%		Төл	Гүйц	%
Асгат	139.1	144.3	147.5	102.2	23.7	33.4	34.9	104.5
Баяндэлгэр	327.3	288.9	322.2	111.5	59.6	77.9	99.4	127.6
Дарьганга	206.4	206.6	233.7	113.1	33.0	61.2	51.1	83.5
Мөнххаан	253.0	253.8	272.2	107.2	51.8	77.9	69.3	89.0
Наран	127.1	128.0	153.6	120.0	27.3	41.7	48.7	116.8
Онгон	365.9	278.4	356.0	127.9	29.5	69.5	58.6	84.3
Сүхбаатар	226.1	228.1	215.9	94.7	44.0	64.0	67.3	105.2
Түвшинширээ	222.0	195.9	221.9	113.3	40.4	55.6	57.4	103.2
Түмэнцогт	262.1	362.7	245.5	67.7	20.3	36.2	32.2	89.0
Уулбаян	221.2	349.1	291.9	83.6	27.4	41.7	42.4	101.7
Халзан	154.9	137.4	146.8	106.8	14.2	27.8	27.9	100.4
Эрдэнэцагаан	504.1	473.8	515.1	108.7	93.2	125.2	145.0	115.8
Баруун-Урт	5 155.6	5 793.9	5 877.1	101.4	145.9	257.4	215.4	83.7
Дүн	8 164.8	8 840.9	8 999.4	101.8	610.3	969.5	949.6	97.9

I.3.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

Сум	Тэтгэвэр авагчдын тоо				Олгосон тэтгэвэр, сая.төг			
	2020.I-VI	2021.I-VI	2022.I-VI	%	2020.I-VI	2021.I-VI	2022.I-VI	%
Асгат	288.0	319.0	320.0	100.3	597.5	668.7	911.2	136.3
Баяндэлгэр	692.0	749.0	738.0	98.5	1 427.7	1 588.2	2 094.0	131.8
Дарьганга	425.0	468.0	473.0	101.1	827.2	984.2	1 330.0	135.1
Мөнххаан	570.0	588.0	591.0	100.5	1 137.0	1 241.4	1 696.2	136.6
Наран	235.0	257.0	256.0	99.6	493.6	551.0	776.7	141.0
Онгон	537.0	569.0	557.0	97.9	1 204.2	1 321.4	1 701.7	128.8
Сүхбаатар	416.0	446.0	418.0	93.7	829.2	922.2	1 285.1	139.4
Түвшинширээ	428.0	412.0	428.0	103.9	829.5	863.8	1 177.5	136.3
Түмэнцогт	396.0	404.0	406.0	100.5	809.9	870.8	1 178.9	135.4
Уулбаян	439.0	467.0	457.0	97.9	877.7	969.0	1 329.7	137.2
Халзан	224.0	249.0	246.0	98.8	449.7	524.3	736.8	140.5
Эрдэнэцагаан	844.0	882.0	972.0	110.2	1 863.4	2 021.9	2 722.1	134.6
Баруун-Урт	3 212.0	3 392.0	3 424.0	100.9	7 387.6	7 877.0	10 328.8	131.1
Дүн	8 706.0	9 202.0	9 286.0	100.9	18 734.2	20 403.9	27 268.7	133.6



I.3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Үзүүлэлт		2021.VI		2022.VI	
		Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Улсын төсөөс	1 Халамжийн тэтгэвэр	1 256	1 804.2	1 338	2 178.7
	2 Халамжийн тэтгэмж	2 118	1 010	2 120	945.0
	1. Асаргааны тэтгэмж	1 102	563	1 109	565.1
	байнгын асаргаа шаардлагатай Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	621	290.6	626	283.3
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	221	102.3	213	95.9
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	219	151.0	226	161.9
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	16	7.4	18	9.9
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	4.5	5	4.5
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	18	7.6	21	9.6
	3 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	5 739	411.2	3 099	165.9
	4 Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт тусламж	4 339	84.4	4 669	163.6
	5 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	-	-	2	0.3
	6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	306	48.2	305	58.0
	7 Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 174	1986.7	4806.	1094.8
	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	3 389	1 727.9	3 785	968.2
Халамжийн сангаас	Жирэмсэн эхийн тэтгэмж	642	134.9	1 015	114.6
	Ихэр хүүхдийн тэтгэмж	11	22.0	6	12.0
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	132	101.9	0	0
	8 Насны хишиг	2 692	437.2	2 836	223.8
	9 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	5 448	719.9	5 347	704.5
	1 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	1016	446.6	1 011	379.9
	Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	803	95.0	759	45.3
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	213	351.6	235	314.2
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	-	-	7	8.4
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	-	-	6	7.2
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	-	-	4	4.8
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	46	30.8	105	42.3
ДҮН		27 088	6 948.4	24 627	5 576.9

**I.4 БОЛОВСРОЛ****I.4.1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД**

Үзүүлэлт	Шалгагдсан			Төгссөн		
	2020-2021	2021-2022	%	2020-2021	2021-2022	%
Төгсөгчид / өдрөөр /	2 785	2 955	106.1	2 785	2 972	106.7
Үүнээс: Бага боловсрол	1 233	1 427	115.7	1 233	1 439	116.7
Суурь боловсрол	858	940	109.6	858	943	109.9
Бүрэн дунд боловсрол	694	588	84.7	694	590	85.0
Төгсөгчид / дүйцсэн /	50	61	122.0	50	58	116.0
Үүнээс: Бага боловсрол	18	12	66.7	18	8	44.4
Суурь боловсрол	32	49	153.1	32	50	156.3
Бүрэн дунд боловсрол	-	-	-	-	-	-
Төгсөгчид / Бүгд /	2 835	3 016	106.4	2 835	3 030	106.9
Үүнээс: Бага боловсрол	1 251	1 439	115.0	1 251	1 447	115.7
Суурь боловсрол	890	989	111.1	890	993	111.6
Бүрэн дунд боловсрол	694	588	84.7	694	590	85.0

I.4.2 ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ ТӨГСӨГЧИД

Үзүүлэлт	Төгсөгчид						Мэргэжлийн боловсрол			
	2019-2020		2020-2021		2021-2022		1 жил		2.5 жил	
	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм
Барилгын өрөг угсрагч	15	-	-	-	32	-	20	-	12	-
Барилгын цахилгаанчин	9	1	-	-	12	11	-	-	24	4
Барилгын сантехник	-	-	11	-	-	-	-	-	-	-
Бетон арматурчин	-	-	6	3	-	-	-	-	-	-
Авто машины засварчин	10	-	14	-	-	-	-	-	-	-
Гагнуурчин	24	-	30	4	46	-	30	-	146	-
Фермерийн аж ахуй эрхлэгч /МАН-ГТ/	20	8	20	7	-	-	-	-	-	-
Тогооч	14	13	22	20	30	24	-	-	30	24
Гоо засалч	9	9	16	16	-	-	-	-	-	-
Модон эдлэлийн мужаан	-	-	8	-	10	-	-	-	10	-
Барилгын засал чимэглэлч	46	6	30	11	62	19	45	12	17	7
Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	51	50	29	28	27	26	27	26	-	-
Ардын бүжгийн бүжигчин	-	-	-	-	12	11	-	-	12	11
Төмөр замын барилгачин	-	-	-	-	-	-	-	-	-	-
Төмөр замын замчин	-	-	-	-	29	11	29	11	-	-
Үндэсний найрал хөгжмийн хөгжимчин	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН	198	87	186	89	272	95	151	49	121	46



I.4.3 ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ ТӨГСӨГЧДИЙН АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ

Үзүүлэлт	Ажлын байртай болсон төгсөгчид		Мэргэжлийн ажил эрхлэлт	Мэргэжлийн бус ажил эрхлэлт	Малчин
	2020-2021	2021-2022			
Барилгын засал чимэглэлчин	12	25	9	7	6
Бетон арматурчин	-	-	1	-	-
Барилгын сантехникч	-	-	3	-	2
Тогооч	8	19	2	5	8
Модон эдлэлийн мужаан	-	7	1	-	6
Гоо засалч	5	-	-	2	3
Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	27	13	5	10	-
Авто машины засварчин	7	-	4	-	6
Фермерийн аж ахуйн эрхлэгч /МААГТ/	15	-	-	-	20
Барилгын цахилгаанчин	5	17	-	-	-
Төмөр замын замчин	-	3	-	-	-
Гагнуурчин	4	15	4	9	8
Барилгын өрөг угсрагч	-	27	-	-	-
Ардын бүжгийн бүжигчин	-	8	-	-	-
ДҮН	83	134	29	33	59

I.5 ЭРҮҮЛ МЭНД

I.5.1 ЭРҮҮЛ МЭНД

	Хэмжих нэгж	2021.I-VI	2022.I-VI	Өсөлт	
				тоо	хувь
1. Нийт үзлэг	мян.хүн	107.9	126.3	18.4	117.1
2. Ор хоног	мян.хүн	47.2	64.4	17.2	136.4
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	37.4	26.8	-10.6	71.7
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	5.7	7.9	2.2	138.6
5. Түргэн тусламжийн дуудлага	мян.хүн	7.8	8.7	0.9	111.5
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.8	1.6	-0.2	88.9
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	150	161	11	107.3
Нийт нас баралт	хүн	167	152	-15	91.0
8. Амаржсан эх	хүн	701	507	-194	72.3
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	709	505	-204	71.2
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	2	6	4	3*
10. 1-5 хүртэлх насны эндсэн хүүхэд	хүн	1	4	3	4*



I.5.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	-	-	1	-
Баяндэлгэр	3	3	1	-
Дарьганга	-	-	1	1
Мөнххаан	1	1	-	-
Наран	-	-	-	-
Онгон	5	5	-	1
Сүхбаатар	4	4	1	-
Түвшинширээ	1	1	-	-
Түмэнцогт	2	2	-	-
Уулбаян	-	-	-	-
Халзан	-	-	1	-
Эрдэнэцагаан	16	16	-	-
Баруун-Урт	475	473	1	1
Дүн	507	505	6	4

I.5.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2020.I-XII	2021.I-XII	Өсөлт	
				тоо	хувь
Бүгд	хүн	1270	3 551	2 281	28.4*
Вируст гепатит	хүн	3	3		0
Гар хөл амны өвчин	хүн	19	1		-18
Цусан суулга	хүн	13	3		-10
Бруцеллёз	хүн	-	1		-
Салхинцэцэг	хүн	3	6		3
Сүрьеэ	хүн	31	37		6
Тэмбүү	хүн	41	21		-20
Трихоминиаз	хүн	40	48		8
Заг	хүн	39	23		-16
Ковид-19	хүн	1081	3 408		2327



I.5.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

Сум	Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд			Вируст гепатит	Гар хөл амны өвчин	Цусан суулга	Салхинцэг	Сүрьеэ	Тэмбүү	Заг	Трихоминиаз	Бруцеллёз	Ковид-19
	2021.I-VI	2022.I-VI	1000 хүн тутамд										
Асгат	28	139	70	1	-	-	-	2	1	-	-	-	135
Баяндэлгэр	22	349	68	-	-	-	-	5	-	1	2	1	340
Дарьганга	18	70	22	-	-	-	-	-	-	-	5	-	65
Мөнххаан	110	146	29	-	-	-	-	-	1	-	2	-	143
Наран	144	26	15	-	-	-	1	-	-	1	-	-	24
Онгон	153	164	43	-	-	-	-	3	1	-	-	-	160
Сүхбаатар	75	105	29	1	-	-	-	3	4	5	4	-	88
